МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Улаанбаатар хот

Дугаар 100

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМГААЛАЛТАД АВАХ ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТЫН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

Цагдаагийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1. Цагдаагийн байгууллагын хамгаалалтад авах онц чухал объектын жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай. /Энэ тогтоолын хавсралтад ЗГ-ын 2015-1-19-ний өдрийн 19, ЗГ-ын 2015-3-30-ны өдрийн 118, ЗГ-ын 2015-7-7-ны өдрийн 278-р тогтоолоор тус тус нэмэлт орсон/

2. Жагсаалтад заасан гэрээгээр (түр) хамгаалах аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулах гэрээний нөхцөл, шаардлагыг тогтоох, гэрээ байгуулах эрхийг Цагдаагийн ерөнхий газрын дарга Б.Билэгтэд зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 91 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.АЛТАНХУЯГ

Хууль зүйн сайд Х.ТЭМҮҮЖИН

Засгийн газрын 2014 оны 100
дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМГААЛАЛТАД АВАХ ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТЫН ЖАГСААЛТ

I. Цагдаагийн төсөвт хамгаалалтад байх объект

1. Гадаадын дипломат төлөөлөгчийн газар;
2. НҮБ-ын суурин төлөөлөгчийн газар;
3. Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв;
4. Улсын бүртгэлийн ерөнхий газрын төв болон үйлчилгээний байрууд, иргэний цахим үнэмлэхийн үйлдвэр;
5. “Изотоп” төв;
6. Улаанбаатар, Чойбалсан, Дархан, Эрдэнэт, Ховд, Даланзадгад хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж;
7. “Дулааны III цахилгаан станц”, “Дулааны IY цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компаниуд;
8. Дөргөний усан цахилгаан станц;
9. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн төв лаборатори;
10. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн лаборатори;
11. Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори;
12. Зоонозын өвчин судлалын үндэсний төв;
13. “Биокомбинат” төрийн өмчит үйлдвэрийн газар;
14. Стандартчилал, хэмжил зүйн газрын төв байр;
15. Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн төв байр, радио, телевизийн эфирийн студи. /ЗГ-ын 2015-1-19-ний өдрийн 19-р тогтоолоор нэмсэн/

II. Цагдаагийн гэрээт хамгаалалтад байх объект

1. Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр, дарь, дэлбэрэх бодисын үйлдвэр, тэсэрч дэлбэрэх бодисын агуулах;
2. “Алтанбулаг" худалдааны чөлөөт бүс, “Цагааннуур” худалдааны чөлөөт бүс;
3. Монголбанкны орон нутаг дахь хэлтэс, салбар /Энэ заалтыг ЗГ-ын 2015-3-30-ны өдрийн 118-р тогтоолоор нэмсэн/
4. Монгол Улсын Хөгжлийн банк /ЗГ-ын 2015-7-7-ны өдрийн 278-р тогтоолоор нэмсэн/

III. Цагдаагийн гэрээт хамгаалалт (түр)-д байх объект

1. Нийслэлийн Засаг даргын тамгын газар (нийслэлийн замын хөдөлгөөн зохицуулах нэгж);
2. Улаанбаатар төмөр замын хувь нийлүүлсэн нийгэмлэг.

-----oOo-----